


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар буюу **24-р долоо хоногт** нийт Нийслэлийн 8 дүүрэг, 11 аймагт **1260** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ аван.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1260 тохиолдлын 94% /1189/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /71/ нь орон нутагт (Баян-Өлгий /10/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /11/, Дорнод /4/, Орхон /4/, Өвөрхангай /4/, Өмнөговь /3/, Төв /25/, Ховд /1/, Хөвсгөл /3/, Увс /1/), тодорхойгүй /2/ бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **355** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.


24 ДҮГЭЭР ДОЛОО ХОНОГТ

(2026.06.07 – 2026.06.13)


2026 оны хорин дөрөвдүгээр долоо хоногт 15 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс өссөн бол 5 жилийн дунджаас 971.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ**

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **1-24 дүгээр долоо хоногт нийт 806** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



2026 оны **хорин дөрөвдүгээр долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **45** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 125 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 188 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (24-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	10	16	26
2	Эмийн хордлого	12	7	19
Нийт		22	23	45

Нийт 45 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 19 (42%) нь эмийн хордлого, 26 (588%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 23 (51%) тохиолдол, санаатай хордлого 22 (49%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-oOo-